



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/22

Мөрөн сум

“Мал угаалгын ванн” барих ажлын явцад
хяналт тавих, хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2026 оны 03 сарын 13-ны өдрийн А/51 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2026 оны 03 сарын 27-ны өдрийн 07 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “НОМТ БАЯН МӨРӨН” ОНӨААТНҮГ Газар нь сумын ОНТ хөрөнгө оруулалтаар “Мал угаалгын ванн” барих ажлын тендерт ялж 2026 оны 03 сарын 30-наас 2026 оны 06 сарын 01 -ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	Н.Амармөрөн	Өлзийт багийн Засаг дарга
Гишүүдэд:	Б.Долгорнямаа	ЖДҮХХ-мэргэжилтэн
	А. Энхтөр	Аж ахуйн нярав
	Р. Төрбадрах	“Зөөлөн булаг” ххк-ын малын эмч
	Д.Дэмбэрэлваанчиг	“Зон дэм” ххк-ын малын эмч

2. “НОМТ БАЯН МӨРӨН” ОНӨААТНҮГ Газраас хүлээн авах “Мал угаалгын ванн” барих ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, чанар, хэмжээ, байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Н.Амармөрөн) -д үүрэг болгосугай.

3. "Мал угаалгын ванн"-ны цаашдын ашиглалтад байнгын хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж ажиллахыг Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-эгжүүдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ